

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 01 (ТОЙМ)

Хуралдаан 2010 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 10.30 цагт эхэлж, 11.40 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 10 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын ажлын байрыг нийтэд зарлуулах тухай	Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын сул ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалтыг 2009 оны 2 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд явуулахаар зарлах болов.
2	Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд нэр дэвшүүлж, дүгнэлт гаргах тухай	Дорноговь аймгийн ЗДТГ-ын даргын албан тушаалд Буураагийн Төмөрхуягийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуягт санал болгох тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
3	"Тагнуулын ерөнхий газрын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын төслийн тухай	Тагнуулын ерөнхий газрын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмын төслийг батлах тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
4	"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын төслийн тухай	"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын төслөө ТАТХ-ийн дугаар зүйлийн 17.8-д зааснаар Ажлын хэсэг дахин ажиллаж, дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав.
5	Засгийн газрын агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл байгуулах тухай	1.ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх ТАЗСЗ-ийг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Тогтоол гүйцэтгэх газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх газрын дарга, Захиргааны удирдлагын газрын дарга, Санхүү, үйлдвэр, төлөвлөлт, бодлого, зохицуулалтын газрын дарга, Тогтоол гүйцэтгэх газрын дэд дарга, Шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга, Хяналт шалгалтын тасгийн дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын шадар туслах, Сургалт, мэргэжлийн ур чадвар хариуцсан ахлах ажилтан нарын 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах, 2.ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх ТАЗСЗ-ийн

		даргаар тус агентлагийн дарга, бригадын генерал Д.Батжаргал, нарийн бичгийн даргаар тус агентлагийн сургалт, мэргэжлийн ур чадвар хариуцсан ахлах ажилтан дэд хурандаа С.Баттогоо нарыг томилох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол тус тус гаргахаар тогтов.
6	Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч асан хурандаа Шилэгийн Энхбатын гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2009 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 08 тоот тушаалаар Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч, хурандаа Шийлэгийн Энхбатыг үүрэгт ажлаас чөлөөлсөн шийдвэрийг хүчингүй болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
7	Засгийн газрын агентлагийн зарим албан хаагчдаас 2009 оны 12 дугаар сарын 29-нд авсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	1.2009 оны 12 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын 6 ажлын байрны сул орон тоонд өрсөлдсөн 23 иргэнийг 1 дүгээр хавсралтаар, Төмөр замын газрын 5 ажлын байрны сул орон тоонд өрсөлдсөн 7 иргэнийг 2 дугаар хавсралтаар, бүгд 30 иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх, 2.Энэ тогтоолын нэгдүгээр зүйлд заасан төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахыг Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга болон томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
8	2009 оны 5 дугаар сард явагдсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын нөөцөд бүртгэгдсэн иргэдээс Баянхонгор аймгийн нэг иргэнийг хасах тухай	ТАЗ-ийн 2009 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 98 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын “Нутгийн захиргааны байгууллагын нэр дээр төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн нэрс”-ийн “Баянхонгор: Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга” гэсний “12.Дагвадоо Батбэх 64.6” гэсэн хэсгийг хасах тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.